

**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГАЗРЫН
ДАРГЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 10, 17 дугаар зүйлийг үндэслэн Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалт /өмнө нь зарлаад хойшилсон/-ыг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаатай зарлаж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий этгээдийн баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байна.

Тухайн ажлын байранд тавигдах шаардлага:

	Чухал шаардлагатай	Шаардлагатай
Боловсрол	Дээд боловсролын магистрын зэрэгтэй	Дээд боловсролын магистр
Мэргэжил	Эрх зүйч, эдийн засагч	Нийгмийн ажилтан
Мэргэшил	Төрийн удирдлагаар мэргэшсэн байх	Удирдах арга барил эзэмшсэн байх
Туршлага	Төрийн албанд 13-аас дээш жил, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх	Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан байх
Ур чадвар	Удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах, хүнийг хөгжүүлэх, баг бүрдүүлж ажиллах, баримт бичиг боловсруулах, хариуцлага хүлээх, харилцааны соёлтой байх, монгол хэл бичгийн дүрэм, найруулга, албан хэрэг хөтлөлтийн талаар мэдлэг, ур чадвартай байх	Асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх чадвартай байх, Бусдыг манлайлах, Ажиллагсад урам хайрлаж ажиллуулж чаддаг байх
Тусгай шаардлага	-Ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, авлигаас ангид ажиллах	

Сонгон шалгаруулалтыг 2017 оны 04 дүгээр сарын 27,28-ны өдөр зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтын бүртгэл:

Сонгон шалгаруулалтад орох иргэний баримт материалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 106 тоот өрөөнд 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 09.00-12.30, 13.30-17.00 цагуудад хүлээн авч, бүртгэнэ. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурьдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:

22. Төрийн албан хаагчийн анкет (маягт №1);
23. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
24. Иргэний үнэмлэх;
25. Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эх хувийн хамт;
26. Ажил байдлын тодорхойлолт;
27. 4x3 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
28. Шалгалтын үйлчилгээний төлбөр 10000 төгрөг.

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

3. Сонгон шалгаруулалтыг Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолоор баталсан зааврын дагуу зохион байгуулна.

Ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын талаар Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn, яамны www.misp.gov.mn цахим хуудаснаас танилцах боломжтой.

ХАРИЛЦАХ УТАС: 262621

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ